



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2025/14/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Дорноговь аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер:

У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор:

О.Нарангарав

Цахим хаяг: narangarav.o@audit.gov.mn

Аудитор:

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.03.25 № 1-6/342

танай _____ -ны № _____ -т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.АНХБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд сумын татварын болон татварын бус нийт 34,960.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 575.2 сая төгрөгөөр буюу 101 хувиар биелүүлсэн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,743.1 сая төгрөгийн 29 алдаа, зөрчил илрүүлснээс 2,656.9 сая төгрөгийн 19 алдааг аудитын явцад залруулж, 2.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 54.6 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 29.4 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

“Ээлтэй Замын-Үүд” хөтөлбөрийн хүрээнд сумын төсөвт байгууллагуудын албан хаагчдад 2024 онд нийт 677.1 сая төгрөг олгосон байна. Урамшууллыг хуваарилахдаа ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын төсвийг шийдвэрлээгүй байна.

442507048

Бусад асуудал

Тайлант онд Замын-Үүд сум байгуулагдсаны түүхт 30 жилийн ой болсонтой холбогдуулан төсвийн харилцах дансаар дамжуулан хандив төвлөрүүлээгүй бөгөөд аж ахуйн нэгж байгууллагаас хандивласан 116.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг сумын Засаг даргын Тамгын газрын дансанд бүртгэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,047,133.9	5,036,102.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,071,714.2	2,377,368.4
33	АВЛАГА	1,083,831.6	613,514.2
34	УРЬДЧИЛГАА	113,592.1	1,136,571.1
35	БАРАА МАТЕРИАЛ	1,730,091.0	848,548.8
36	НӨӨЦИЙН БАРАА	47,905.0	60,100.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,033,845.7	5,938,271.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,033,845.7	5,938,271.8
39200	Биет хөрөнгө	3,987,484.0	5,892,108.8
39300	Биет бус хөрөнгө	46,361.8	46,163.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,080,979.6	10,974,374.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	370,287.4	883,502.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	370,287.4	883,502.2
41300	Өглөг	370,287.4	883,502.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,710,692.2	10,090,872.1
51	Засгийн газрын хувь оролцоо	7,710,692.2	10,090,872.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	526,058.9	526,058.9
51200	Хуримтлагдсан үр дүн	6,500,126.0	8,880,306.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	684,507.2	684,507.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,080,979.6	10,974,374.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	28,134,187.5	50,986,892.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	20,067,164.6	32,481,285.7
110	Орлогын албан татвар	9,389,704.3	14,464,783.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	9,389,704.3	14,464,783.5
113	Хөрөнгийн албан татвар	669,534.1	1,148,590.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	10,007,926.2	16,867,912.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,439,560.9	6,211,856.5
120	Нийтлэг татварын бус орлого	3,439,560.9	6,211,856.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,627,461.9	12,293,750.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	26,149,883.4	47,415,347.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,149,883.4	47,415,347.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,301,919.8	27,293,831.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,181,126.0	4,562,697.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	414,599.8	579,610.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	159,831.4	2,461,681.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4,552,009.4	8,794,700.2
2105	Нормативт зардал	223,329.6	238,093.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	126,783.9	278,836.9
2107	Томилолт, зочны зардал	29,182.9	58,562.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,421,493.7	9,511,659.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,193,563.1	807,991.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,847,963.6	20,121,515.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,984,304.1	3,571,545.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	222,305.8	1,003,649.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,761,998.3	2,567,895.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,922,034.4	5,922,034.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	26,659.5	26,659.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,948,693.9	5,948,693.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-
9	Тайлант үеийн үр дүн	1,761,998.3	1,761,998.3
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,710,692.2	7,710,692.2
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,710,692.2	7,710,692.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(187,715.6)	(187,715.6)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,522,976.6	7,522,976.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-
19	Тайлант үеийн үр дүн	2,567,895.5	2,567,895.5
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,090,872.1	10,090,872.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	34,676,735.6	48,073,111.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	20,067,164.6	32,481,285.7
110	Орлогын албан татвар	9,389,704.3	14,464,783.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	9,389,704.3	14,464,783.5
113	Хөрөнгийн албан татвар	669,534.1	1,148,590.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	10,007,926.2	16,867,912.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,898,289.4	15,942,654.2
1181	Газрын төлбөр	1,109,636.8	925,257.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,758,770.5	3,026,717.8
120	Нийтлэг татварын бус орлого	1,758,770.5	3,026,717.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,850,800.5	12,531,007.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30,988,488.0	39,489,903.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,988,488.0	39,489,903.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,989,247.2	17,795,488.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,190,812.5	4,518,429.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	407,017.0	564,661.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	159,831.4	2,461,700.0
2104	Хангамж, бараа материалын зардал	399,967.5	474,359.3
2105	Нормативт зардал	84,476.4	98,606.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	132,328.8	361,350.5
2107	Томилолт, зочны зардал	37,913.8	63,580.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,643,681.8	8,633,645.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,933,217.9	619,155.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,999,240.8	21,694,415.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,688,247.6	8,583,207.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,704,672.9	7,277,553.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,704,672.9	7,277,553.6
2200	Дотоод эх үүсвэрээр	3,704,672.9	7,277,553.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,704,672.9)	(7,277,553.6)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(16,425.3)	1,305,654.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,088,139.5	1,071,714.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,071,714.2	2,377,368.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,338,023.0	18,000,477.6	3,337,545.4	84.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,290,489.3	10,857,832.7	1,432,656.6	88.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,984,534.7	8,582,843.9	1,401,690.8	86.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,623,363.7	3,467,531.3	155,832.4	95.7
210101	Үндсэн цалин	1,122,938.1	1,073,372.3	49,565.8	95.6
210102	Нэмэгдэл	1,044,410.3	922,056.8	122,353.5	88.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	260,253.2	254,873.2	5,380.0	97.9
210104	Урамшуулал	143,707.8	125,541.5	18,166.3	87.4
210105	Гэрээт ажлын хөлс	1,052,054.3	1,091,687.7	(39,633.4)	103.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	485,263.6	448,005.5	37,258.1	92.3
210201	Тэтгэврийн даатгал	325,307.8	309,993.5	15,314.3	95.3
210202	Тэтгэмжийн даатгал	39,989.0	35,799.3	4,189.7	89.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	31,991.0	23,477.4	8,513.6	73.4
210204	Ажилгүйдлийн даатгал	7,997.9	11,328.9	(3,331.0)	141.6
210205	Эрүүл мэндийн даатгал	79,977.9	67,406.3	12,571.6	84.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,720,449.2	2,438,495.9	281,953.3	89.6
210301	Гэрэл, цахилгаан	286,818.4	236,350.8	50,467.6	82.4
210302	Түлш, халаалт	2,164,192.1	1,975,301.4	188,890.7	91.3
210303	Цэвэр, бохир ус	269,438.7	226,843.7	42,595.0	84.2
2104	Хангамж, бараа материалын зардал	443,605.0	422,301.8	21,303.2	95.2
210401	Бичиг хэрэг	27,456.2	25,125.0	2,331.2	91.5
210402	Тээвэр, шатахуун	343,282.5	331,082.5	12,200.0	96.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,700.0	14,358.1	3,341.9	81.1
210404	Ном, хэвлэл	21,500.0	21,491.7	8.3	100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100.0	1,008.2	91.8	91.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,566.3	29,236.4	3,329.9	89.8
2105	Нормативт зардал	35,000.0	35,000.0	-	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	35,000.0	35,000.0	-	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	401,352.9	392,173.0	9,179.9	97.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	80,952.9	79,809.5	1,143.4	98.6
210602	Тавилга	30,500.0	29,594.0	906.0	97.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,000.0	7,995.7	4.3	99.9
210604	Урсгал засвар	281,900.0	274,773.8	7,126.2	97.5
2107	Томилолт, зочны зардал	62,596.0	58,565.6	4,030.4	93.6
210702	Дотоод албан томилолт	27,596.0	25,330.0	2,266.0	91.8
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	35,000.0	33,235.6	1,764.4	95.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,580,988.7	1,016,111.0	564,877.7	64.3

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,544,753.3	991,185.6	553,567.7	64.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,300.0	3,800.0	500.0	88.4
210803	Даатгалын үйлчилгээ	8,140.0	3,949.7	4,190.3	48.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,596.3	2,955.4	1,640.9	64.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	4,029.0	2,857.0	1,172.0	70.9
210807	Газрын төлбөр	15,170.1	11,363.3	3,806.8	74.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	631,915.6	304,659.7	327,255.9	48.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	630,269.2	303,013.5	327,255.7	48.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,646.4	1,646.3	0.2	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,305,954.6	2,274,988.9	30,965.7	98.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,582,681.6	1,552,021.2	30,660.4	98.1
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,582,681.6	1,552,021.2	30,660.4	98.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	723,273.0	722,967.7	305.3	100
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	687,050.0	686,950.0	100.0	100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,723.0	18,723.0	-	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,500.0	17,294.7	205.3	98.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,047,533.7	7,142,644.8	1,904,888.9	78.9
223001	Бусад хөрөнгө	9,047,533.7	7,142,644.8	1,904,888.9	78.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,338,023.0	18,306,786.8	3,031,236.2	85.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,475,681.6	1,465,878.4	9,803.2	99.3
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	1,475,681.6	1,465,878.4	9,803.2	99.3
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19,433,193.9	16,299,710.9	3,133,483.0	83.9
320001	Орон нутгийн төсвөөс	19,433,193.9	16,299,710.9	3,133,483.0	83.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	429,147.5	541,197.5	(112,050.0)	126.1
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,227.8	353,260.7	(301,032.9)	676.4
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,000.0	187,936.8	(157,936.8)	626.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	346,919.7	-	346,919.7	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	390,423.8	(390,423.8)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	696,733.1	(696,733.1)	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	7,683.6	(7,683.6)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	7,683.6	(7,683.6)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	7,601.8	(7,601.8)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	7,596.2	(7,596.2)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	7,596.2	(7,596.2)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5.6	(5.6)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5.6	(5.6)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	81.8	(81.8)
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	81.8	(81.8)
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	81.8	(81.8)
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	7,683.6	(7,683.6)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	7,683.6	(7,683.6)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,360.9	(7,360.9)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	322.7	(322.7)

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн байгууллагын 4, орон нутгийн хөрөнгө оруулалтын 1, тусгай сангийн 3 нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 төсвийн байгууллагад дүгнэлт гаргаж, 2 төсвийн байгууллага, тусгай сангийн 2 тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийх аудит хийсэн.

Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн тусгай сангийн болон Орон нутгийн хөрөнгө оруулалтын дансны санхүүгийн тайлангуудыг аудит хийх байгууллагын тоонд оруулж, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хугацаанд аудитад хамруулж, шалгасан болно.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудын 1 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,743.1 сая төгрөгийн 29 алдаа, зөрчил илрүүлснээс 2,656.9 сая төгрөгийн 19 алдааг аудитын явцад залруулж, 2.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 54.6 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 29.4 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмжийг хүргүүллээ.

Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

Илрүүлэлт:

“Ээлтэй Замын-Үүд” хөтөлбөрийн хүрээнд сумын төсөвт байгууллагуудын албан хаагчдад 2024 онд нийт 677.1 сая төгрөг олгосон байна. Урамшууллыг хуваарилахдаа ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын төсвийг шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-д “Монгол Улсын иргэн, ... төрийн албан хаагч албан журмаар даатгуулна”, 19 дүгээр зүйлийн 19.1.3-д “ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал”, 21 дүгээр зүйлийн 21.9-д “даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, урамшууллаас даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, ажил олгогч нийгмийн даатгалын санд төлнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын төсвийг хамт шийдвэрлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Иргэдийн төлөөлөгчдийн Хурал	1	0.1	-	-	1	0.1	1	0.1	-	-	-	-
Засаг даргын Тамгын газар	6	44.3	-	-	6	44.3	6	44.3	-	-	-	-
Захирагчийн ажлын алба	2	29.1	-	-	2	29.1	2	29.1	-	-	-	-
Орон нутгийн хөгжлийн сан	2	1,536.5	-	-	2	1,536.5	2	1,536.5	-	-	-	-
Хоршоо хөгжүүлэх сан	2	9.2	-	-	2	9.2	2	9.2	-	-	-	-
ӨЭМТ	6	1,037.7	3	997.6	3	40.1	6	1,037.7	-	-	-	-
Дүн	19	2,656.9	3	997.6	16	1,659.3	19	2,656.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3	11.9	1	0.7	1	11.2	1	-	-	-	-	-	-
Засаг даргын Тамгын газар	4	53.8	1	1.5	1	43.4	2	8.9	-	-	-	-	-
Захирагчийн ажлын алба	1	1.6	-	-	-	-	1	1.6	-	-	-	-	-
Орон нутгийн хөгжлийн сан	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
ӨЭМТ	1	18.9	-	-	-	-	1	18.9	-	-	-	-	-
Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Дүн	11	86.2	2	2.2	2	54.6	7	29.4	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Орон нутгийн хөгжлийн сан	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	-

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	1				1		
2	Сумын Засаг даргын Тамгын газар	1	1			1			
3	Сумын Захирагчийн ажлын алба	1		1					
4	Сумын Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
5	Сумын Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
6	Борхойн наран ӨЭМТ	1		1					
7	Сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	1			1			
НИЙТ		7	3	4	-	2	1	-	-